


**“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Тайлагнах хугацаа		2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/
Үнэт цаас гаргагчийн нэр Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар үнэт цаасны код, утасны дугаар		“Улаанбаатар БҮК” ХК 9010001027 976-70001182
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Барилгын салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		131'547'500 ширхэг
2025 оны хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Байгальмаа Хянасан: Гүйцэтгэх захирал..... Г.Ганболд
1.	2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	МХБ-ийн сайтад
	Орлогын тайлан	МХБ-ийн сайтад
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	МХБ-ийн сайтад
	Мөнгөн гүйлгээний тайлан	МХБ-ийн сайтад
1.1	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	МХБ-ийн сайтад
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Энэхүү тайлангийн хавсралтад тусгагдсан
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Энэхүү тайлангийн хавсралтад тусгагдсан .
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Компанийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт өөрчлөлт гараагүй
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл:	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
4.	Цалин урамшуулал мэдээлэл: 2025 онд ХЭХ-аас ТУЗ-ийн төсвийг 248,850.300 /хоёр зуун дөчин найман сая найман зуун тавин мянга гурван зуун/ төгрөгөөр баталсан ба төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Гүйцэтгэх захирлын урамшууллыг бизнес төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэлийг үндэслэн ашгийн 5% хүртэл хэмжээтэй олгох нөхцөлийг гэрээнд тусгаж ажилладаг.	

Олон нийтэд санал болгож хувьцаа гаргаагүй.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл <p>1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны 2025 оны эцсийн жилийн тайланг 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр ТУЗ-өөр хэлэлцэн “хангалттай” гэж дүгнэсэн ба мэдээллийг Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>2. Компанийн тухай хуульд заасны дагуу ХЭХ-ыг 2025 оны 4 сарын 04-ний өдөр зарлан хуралдуулсан ба мэдээллийг хувьцаа эзэмшигчид үйлчилдэг брокер диллерийн компани, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн. ХЭХ-тай холбоотой 154 хуудас баримт материалыг баталгаажуулан СЗХ, Хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд хүргүүлсэн.</p> <p>3. Санхүүгийн тайлан, Компанийн удирдлагатай холбоотой мэдээллийг тухай бүр МХБ, СЗХ зэрэг байгууллагуудын веб сайтанд тавьж нийтэд ил тод хүргэх арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>4. Компанийн засаглалын кодекст заасан зарчим, Компанийн тухай хуулийн заалтын дагуу Аудит, эрсдлийн хорооны шийдвэрээр “Улаанбаатар БҮК”ХК-ийн 2025 оны санхүүгийн байдлын хагас жил, жилийн эцсийн тайланд “Пи Кэй Эф-Ай Эй Эс Аудит” ХХК –иар хөндлөнгийн аудит хийлгэн мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>5. ТУЗ-өөс 2025 онд 13 ажил төлөвлөсөн ба тэдгээрийн биелэлт 84,6%-тай байна. 2 ажлыг 2026 оны эхний хуралд хэлэлцэхээр хойшлуулсан.</p> <p>6. 2025 онд “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-нь нийт 9 удаа хуралдсан ба 5 удаа ердийн, 4 удаа эчнээ хуралдаж 24 асуудал хэлэлцэж, 17 тогтоол баталж, 7 шийдвэрийг хурлын тэмдэглэлд тусгаж биелэлтэнд зохих хяналтыг тавьж ажилласан. Мөн ээлжит ХЭХ-ын бэлтгэл ажлыг хууль дүрмийн дагуу зохион байгуулж байгаа ба 4 сарын 30-нд хуралдуулахаар ТУЗ шийдвэрлэсэн.</p> <p>7. Компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгох талаар Санхүүгийн Зохицуулах хорооноос өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангах хүрээнд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг ханган, тухай бүр зохих маягтын дагуу тайланг гаргаж хууль тогтоомжид заасан хугацаанд СЗХ, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлж ажиллаж байна. / 2025 оны “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн тайланг МХБ-ийн сайт болон Компанийн веб хуудсанд байршуулсан.</p>
6.	Зах зээлийн эрсдлийн мэдээлэл <p>Зах зээлийн эрсдлийн талаарх шинжилгээг МБХ-ээс тухай бүр гүйцэтгэж мэдээллийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж зохих арга хэмжээг авч ажилласан.</p>
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ <p>“Улаанбаатар менежмент “ХХК 128,315,700ш /97,5%/ бусад буюу 910 хувьцаа эзэмшигчид 3,231,800 ш /2,5%/ хувьцаа эзэмшдэг.</p>
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл <p>Төсөл хэрэгжүүлээгүй.</p>
9	Ногдол ашгийн мэдээлэл <p>”Улаанбаатар БҮК”ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ шийдвэрлэсэн ба тогтоолыг СЗХ-д хүргүүлсэн.</p>
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл <p>Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар дотоод журамдаа тусган мөрдөж ажиллаж байгаа ба сар бүр дундаар 30-50 ажилтнуудын нийгмийн асуудлыг амаар болон бичгээр шийдвэрлэн ажилласан байна. 2025 онд Компани 271 ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулан энэхүү үйл ажиллагаанд 17 сая 344,0 мянган төгрөг зарцуулсан.</p>
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Дашрэнцэн Байгальмаа Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: 	

ХАВСРАЛТУУД

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

№	Овог	Нэр	Мэргэжил	Ажлын туршлага	Хувьцааны эзэмшлийн хувь, хэмжээ
ЕРДИЙН ГИШҮҮД					
1	Даваа	Нямхүү	Технолог инженер	-1998-2000 “Монциркон” ХХК, Ерөнхий захирал - 2004-2008 НИТХурал, Төлөөлөгч - 2008-2012 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Дэд сайд - 2012-2014 “УБ БҮК” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2015-2016 Аж үйлдвэрийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга - 2016-2017 “Улаанбаатар менежмент”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2017-хойш “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн дарга	
2	Дорж	Мөнхөө	Физикч	-1988-1989 “Шинжлэх ухааны хүрээлэн”, мэргэжилтэн - 1989-1991 УАЗТЭШ төв, инженер - 1992-2000 “Монциркон” ХХК, захирал - 2001 оноос одоог хүртэл “Улаанбаатар Менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал -2010 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	219249 ш/0,0017%/
3	Чапанов	Мухамед Абракович	Санхүү менежер	- 2010-2012 онд: “Орион интернейшнл”ХХК-ийн орлогч захирал - 2012-2013 онд: “Улаанбаатар менежмент” ХХК-д санхүүгийн менежер - 2013-одоог хүртэл “Улаанбаатар менежемент”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2013 оноос одоог хүртэл “Улаанбаатар менежемент”ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал - 2020 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	113580 ш/0,00086%/
4	Хамхоев	Харон Юсупович	Эдийн засагч	- 1990-1992“Лион ЛТД” ХХК, орлогч захирал - 1994-1997“Браз” ХХК-ийн Бээжин дэхь төлөөлөгчийн газар, орлогч захирал - 1992-1994“Браз” ХХК-ийн Казакстан дахь төлөөлөгчийн газар ,орлогч захирал - 1995-2000“Орион Интернейшнл” ХХК, ТУЗ-ийн дарга - 2000 оноос одоог хүртэл “Улаанбаатар менежмент”ХХК-ийн ТУЗ-ийн дарга -2010 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	
5	Хадбаатар	Золжаргал	Математикч	Шинжлэх ухаан, техник, дээд боловсролын улсын хороо-Эрдэм шинжилгээний ажилтан “Таван сум”ББХК-Ерөнхий захирал “Шинэст”ХК-дэд захирал Хөдөлмөр нийгмийн хамгаалал улсын хяналтын албанд мэдээлэл гадаад харилцааны хэлтсийн дарга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	

				Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 -2020 онд: “УЛААНБААТАР МЕНЕЖМЕНТ” ХХК-ийн Судалгаа хөгжлийн асуудал эрхэлсэн захирал 2020 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн Гүйцэтгэх захирал 2020 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	
6	Отгонсүрэн	Басанхүү	Физикч, багш	1989-1991 онд МУИС-д багш,инженер 1991-1996 онд “Монгол газар “ХХК-д менежер 1998-2003 онд “Монциркон”ХХК-д менежер 2004-2009 онд “МЭАТ”ХХК-д Дэд захирал 2010 оноос одоог хүртэл “Метаалресурс”ХХК-ийн захирал 2020 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	
ХАРААТ БУС ГИШҮҮД					
7	Громов	Сергей Борисович	Инженер	<ul style="list-style-type: none"> - “Trans World” компани – Сангийн хэлтсийн дарга - “Разноимпорт” компани – Менежер - “АПУ”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн - “Монгол даатгал”ХХК-ийн ТУЗ-ийн дарга - “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн 	
8	Гомбо	Ганболд	Төрийн удирдлага, эдийн засаг	<p>-2022 – 2024, Захиргаа Удирдлагын газрын дарга, 100%-ийн төрийн өмчит Дархан Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,</p> <p>-2021-2022, Металлын төсөл хөтөлбөр хариуцсан захирал, ЗГХЭГ-ын 100%-ийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК,</p> <p>-2016-2021, Санхүү хариуцсан дэд захирал ЗГХЭГ-ын 100%-ийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК,</p> <p>-2011-2016, Ерөнхий захирал, ТУЗ-ийн дарга, “Монгол Алтан Тос” ХХК /Ургамлын цэвэр тосны үйлдвэр/</p> <p>-2005-2016, Дархан-Уул аймаг дахь Чингис Хаан банкы төлөөлөгч, 1-р салбарын захирал</p> <p>-2003-2005, Дархан-Уул аймаг дахь Интер банкны 04-р салбарын захирал</p> <p>-1999-2003, Сургалтын албаны менежер, “Нягтлан бодох бүртгэл”, “Эдийн засгийн онол” “Банк санхүү” багш, Монгол Улсын Хөдөө Аж ахуйн Их Сургууль, УГТСЭШХүрээлэн</p> <p>Төрийн өмчит компанийн ТУЗ-д хашсан алба:</p> <p>-2017-2022 онуудад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэр бүхий охин компаниудын ТУЗ-ийн гишүүн, даргаар ажиллаж байсан болно. Үүнд:</p> <p>-“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК - ТУЗ-ийн дарга, “Эрдэнэс Алт Ресурс” ХХК – ТУЗ-ийн дарга, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК – ТУЗ-ийн дарга, “Монголын - Эрдэс Баялгийн Бирж” ХХК -ТУЗ-ийн дарга, “Багануур” ХК – ТУЗ-ийн гишүүн.</p>	

				-2025 –оны 4 сараас “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	
9	Чулуундорж	Энхбат	Инженер	2004-2008 онд:Тээвэр үйлчилгээний дарга 2008-2012 онд: “Сан транс” ХХК-д Гүйцэтгэх захирал 2012-2016 онд:Нийслэлийн Тээврийн газрын дарга 2017 оноос одоог хүртэл “АХОИ” ХХК-д Ерөнхий захирал 2021 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн	

2 ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцсон оролцоо:



3.Гүйцэтгэх удирдлагын баг

№	Овог нэр	Албан тушаал	Хүйс	Томилогдсон огноо	Мэргэжил
1	Х.Золжаргал	Гүйцэтгэх захирал	эр	21/05/2020	Математикч
2	Р.Г.Мирзоев	Үйлдвэрлэл эрхэлсэн захирал	эр	11/04/2020	Уулын инженер
3	Хамхоев Магомед Харонович	Санхүү эрхэлсэн захирал	Эр	2024/5/24	Математикч
4	Н.Хунцэнгэл	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	эм	20/10/2020	Бизнесийн удирдлага
5	Б.Нармандах	Ерөнхий инженер	эр	03/25/2013	Металургийн инженер
6	Б.Сапербек	Үйлдвэр техник технол дарга	эр	05/08/2020	Барилгын инженер
7	Ө.Дэлгэрмаа	Ерөнхий нягтлан бодогч	эм	01/10/2023	Нягтлан бодогч

**4. “УЛААНБААТАР БҮК”ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
2025 оны жилийн эцэс**

№	Компанийн засаглалын үндсэн зарчим	Үнэлгээний асуулга	Хэрэгжилт	
			оноо	хувь
1	ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна	12	100
2	ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	10	100
3	ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	6	100
4	АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана	6	100
5	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина	8	100
6	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	5	83.3
7	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	8	100
8	КОМПАНИЙН СОЁЛ	ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	6	100
9	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	10	100
нийт үнэлгээ			71	98.11

5.БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Борлуулалт

2025 оны борлуулалтын мэдээ, төгрөг

Бүтээгдэхүүн	2025 төлөвлөгөө /м3/	2025 гүйцэтгэл /м3/	2025 төлөвлөгөө /сая төг/	2025 гүйцэтгэл /сая төг/	Борлуула эзлэх ж
1.ТБ хийц эдлэл :	52,728.8	20,109.4	95,740.6	34,125.6	94%
1.1 Voltamix: Хоолой, цагираг	6,474.6	3,354.8	8,323.4	5,072.7	14%
1.2 Tensiland: Хашаа шон	4,743.2	3,110.5	8,629.1	3,085.8	9%
1.3 ТЗ-ТБ дэр	32,828.6	2,196.4	67,673.8	5,001.2	14%
1.4 Бусад	8,682.4	11,447.6	11,114.3	20,965.9	58%
1.4.1 Стандарт	6,698.8	2,494.4	6,958.1	3,145.2	9%
1.4.2 Стандарт бус	1,983.60	8,953.3	4,156.2	17,820.8	49%
2. Металл хийц	-	-	-	408.8	1%
3.Бусад элдэв орлого	-	-	-	1,725.5	5%
Дүн	52,728.8	20,109.4	95,740.6	36,259.9	100%

2025 оны эцсээр нийт 36,260 тб төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөө 37.8% биелэсэн. Нийт борлуулалтад төмөр бетон эдлэл 94%, метал 1%, элдэв бусад орлого 5% эзэлж байна.

Компанийн санхүү эдийн засгийн үзүүлэлтүүд

2025 оны орлого, үр дүн

ҮЗҮҮЛЭЛТ	ХН	2021	2022	2023	2024	2025 төсөв	2025 гүйцэтгэл	Гүйц/Төсөв
А	Б	1	2	3	4	5	6	=6/5
Үүнээс: Метал хийц	тонн	146	283	265	288	300	580	193%
ТБХЭ	м3	10332	12,188	17,716	13,230	18,672	20203	108%
ТЗ-ТБ дэр	м3	21146	30,012	5,583	2,970	32,512	10,814	33%
Борл. Орлого (БО)	сая.төг	39,167	72,085	37,055	43,455	96,241	36,260	38%
Үүнээс: Метал хийц	сая.төг	-	374	56.4	81	500	408.8	82%
ТБХЭ	сая.төг	7,527	14,024	16,417	16,864	28,777	29,124	101%
ТЗБ дэр	сая.төг	31,419	56,441	19,650	18,113	66,964	5,001	7%
Бусад элдэв орлого	сая.төг	221	1,246	775	8,397	0	1,725	
Борл. Бүт-ний Өртөг	сая.төг	23,616	52,546	21,259	25,259	63,867	18,996	30%
ББӨ / Бор-лт	хувь	60%	73%	57%	58%	66%	52%	79%
НИЙТ АШИГ	сая.төг	15,551	19,539	15,639	18,196	32,374	17,264	53%
Нийт ашгийн хувь	Хувь	40%	27%	42%	42%	34%	48%	142%
Борл.Уд-н Зардал (БУЗ)	сая.төг	12,132	15,579	15,123	12,984	17,086	15,733	92%
БУЗ/БО %	хувь	32%	22%	41%	30%	18%	43%	244%
Бусад орлого, зардал	сая.төг	183	(1,835)	(67)	(558)	162	(280)	-172%
Татварын өмнөх ашиг	сая.төг	3602	2,125	449	4,654	15,450	1,250	8%
Орлогын татвар	сая.төг	382	233	72	533	2,962	150	5%
Цэвэр Ашиг /Алдагдал	сая.төг	3,220	1,892	377	4,121	12,487	1,100	9%
Цэвэр ашгийн хувь	хувь	8%	3%	1%	9%	13%	3%	23%
Нэгж хувьц-нд ногдох ЦА	төг	24.48	14.4	2.8	31.33	94.93	8.36	9%
Ажилтны тоо, дунджаар	хүн	267	306.2	279	266	342	282	82%
Бүтээмж: Орлого/Хүний тоо	Сая төг	147	235	133	163	281	129	46%
Хөрөнгө оруулалт	Сая төг	2922	2950	2876		1237	1474	119%

5.2. Санхүүгийн харьцаанууд

Санхүүгийн харьцааны нэр	Үзүүлэлт	Хэвийн түвшин	2021	2022	2023	2024	2025
Төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ							
Эргэлтийн Харьцаа (current ratio)	ЭХ/БХӨ	> / 1-2	1.8	1.48	1.57	3.01	1.44
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	(ЭХ-БМ)/БХӨ	> / 0.4-0.8	0.3	0.25	0.19	0.28	0.22
Өөрийн Капиталын оролцоо хувь	ЭӨ/НХ	> / 0.25-0.5	0.74	0.62	0.65	0.74	0.51
Өр төлбөр ба эзэмш. өмчийн харьцаа (debt-to-equity ratio)	ӨТ/ЭӨ	< / 1-2	0.3	0.62	0.53	0.35	0.94
Өрийн харьцаа (эх үүсв. квот)	ӨТ/НХ	< / 1-1.5	0.26	0.38	0.35	0.26	0.49
Хөрөнгө ашиглалтын шинжилгээ							
Нийт хөр. эргэц (Asset turnover)	БО/НХ	>1	0.56	0.84	0.46	0.56	0.33
ҮХ-ийн эргэц (FA Turnover)	БО/ЭБХ	>2	1.03	1.92	1.00	1.10	0.82
Авл-н эргэц, удаа (AR turnover)	БО/Д.Авл	>8	13.8	18	7.3	7.9	1.7
Авл. эргэц, барагдуулах хоног	Д.Авл/БО*3 65	<45	26.5	20.2	49.8	46.2	53.2
БМ-эргэц, удаа (Inv-ry turnover)	ББӨ/Д.БМ	3<X<5	0.9	1.3	0.56	0.46	0.43
Бараа материалын эргэц, хоног	(БМ/ББӨ)*3 65	70<X<120	406	280	657	495	857
Компанийн ашигт ажиллагааны шинжилгээ							
Ашгийн норм /нийт ашгаар/	НА/БО	45%-60%	40%	27%	42%	42%	48%
Ашгийн норм /ЦА-аар тооцсон/	ЦА/БО	>= 10%	7.7%	3.2%	1.0%	9.5%	3%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	ТӨА/НХ	5%-15%	5.0%	3.0%	0.6%	6.0%	1%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	ЦА/ЭӨ	10%-20%	5.8%	4.4%	0.7%	7.2%	2%